



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/631

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн номын сангийн гэрэл цахилгаан, цэвэр бохир усны зардалд 6,285,000 (зургаан сая хоёр зуун наян таван мянга) төгрөг, Аймгийн Музейн урсгал үйл ажиллагааны зардалд 2,736,700 (хоёр сая долоон зуун гучин зургаан мянга долоон зуу) төгрөг, Арвайхээр тохижилт үйлчилгээ ОНӨАТҮГазрын ажилчдын цалингийн зардалд 30,000,000 (гучин сая) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх зардалд нийт 39,021,700 (гучин есөн сая хорин нэгэн мянга долоон зуун) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101355